



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# Монгол улсын 2015 оны Нэгдсэн Төсвийн Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хийсэн тойм дүгнэлт

*Хэлэлцүүлэгт зориулсан тойм*

Судлаач: Д.Баярмаа  
ШУТИС Докторант

2014 оны 11-р сар

# Тайлангийн товч агуулга

Зөвлөх баг Нээлттэй Нийгэм Форумтай байгуулсан гэрээний дагуу Монгол улсын Нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлтийг 2014 оны 10-р сарын 1- нээс эхлэн 2014 оны 10-р сарын 28-ны хооронд боловсруулсан болно.

Зөвлөх багийн боловсруулсан тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтсан:

- 2014 оны 3-р улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэл
- 2015 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт
- Төсвийн гадуурх санхүүжилт, төсвийн эрсдлийн дүгнэлт
- 2015 оны нэгдсэн төсвийн тэнцэл, өрийн талаар тойм дүгнэлт

Тайлангийн үндсэн зорилго нь төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий байдлаар танилцуулах явдал юм. Мөн төсвийн төлөвлөлт болон Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалтай төсвийн төсөл хэрхэн уялдаж байгааг тодруулан, түүнд хараат бус дүгнэлт өгөхөд оршино.

Энэхүү танилцуулгыг боловсруулахдаа Сангийн яамны төсвийн мэдээллүүд, Монголбанк, ҮСХ, Олон Улсын Валютын сан, Дэлхийн банк, бусад олон улсын судалгааны байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлан боловсруулав.

- 1 2014 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
- 2 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАНИЛЦУУЛГА
- 3 ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ МЭДЭЭ
- 4 ДҮГНЭЛТ


- 1 2014 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
- 2 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАНИЛЦУУЛГА
- 3 ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ МЭДЭЭ
- 4 ДҮГНЭЛТ

# 2014 оны 3-р улирлын байдлаар нийт хөрөнгийн зардлын гүйцэтгэл 48.9%, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 42.2% байна.

## Хөрөнгийн зардал 3-р улирлын байдлаар “Төлөвлөлт ба гүйцэтгэл”


Их Наяд төгрөг

% 2014 оны 9-р сарын гүйцэтгэлийн харьцуулсан %



## Хөрөнгийн зардлын санхүүжүүлэх эх үүсвэр

Хувь, %



Эх үүсвэр: Сангийн яам,


## Тойм дүгнэлт

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 1.7 их наяд төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 0.8 их наяд төгрөг буюу 48.9%-ийн гүйцэтгэлтэй байна.
- 2014 оны 9 дүгээр сарын хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг 2014 оны жилийн төлөвлөгөөтэй харьцуулвал 42.5%-ийн гүйцэтгэлтэй байна.
- Нийт хөрөнгийн зардлын 88.8%-ийг дотоод эх үүсвэрээр, 11.2%-ийг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.
- 2014 онд улсын төсвөөс нийт хөрөнгийн зардлын 76.7% буюу 1135.9 тэрбум төгрөгийг **хөрөнгө оруулалтын** төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 478.9 сая төгрөгийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн бөгөөд **хөрөнгө оруулалт 42.2%**-ийн гүйцэтгэлтэй байна.
- Төсвийн орлогын эх үүсвэрийн байдалтай уялдуулан 2014 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс хойш худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлах, дүгнэх, гэрээ байгуулах ажлын санхүүжилтийг энэ оны төсвөөс санхүүжүүлэхгүй байх, ирэх оны төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэхээр Засгийн газраас шийдвэрлэсэн.

# Дэд бүтэц, нийгэм, үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар дахь улсын хөрөнгийн зардлын гүйцэтгэл 50%-иас доогуур байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2014 оны 3-р улирлын байдлаар (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

Хувь, %



Эх үүсвэр: Сангийн яам,

- 1 2014 ОНЫ ЭХНИЙ 3-Р УЛИРЛЫН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
- 2 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАНИЛЦУУЛГА
- 3 ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ МЭДЭЭ
- 4 ДҮГНЭЛТ

# 2015 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулсан.


## Хөрөнгийн зардал

Их Наяд төгрөг



## Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Их наяд төгрөг



Эх үүсвэр: Сангийн яам,

## Тойм дүгнэлт

- 2015 Монгол улсын нэгдсэн төсвийн нийт зардлыг 7.63 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд нийт зардлын 19.4% буюу 1.48 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тооцсон.
- 2015 онд хөрөнгийн зардлын хэмжээг өмнөх оны тодолтголоор батлагдсан түвшнээс 519.0 тэрбум төгрөгөөр буюу 26%-иар бууруулж төсөвлөсөн.
- Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь өмнөх жилүүдээс буурч 6.2% болжээ.
- 2015 онд 627.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын төсвөөс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ нь өмнөх оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 508.3 тэрбум төгрөгөөр буюу 44.7%-иар буурсан үзүүлэлт юм. Харин 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 148.7 тэрбум төгрөгөөр буюу 31%-иар өссөн.
- 2012 он хүртэл эрчимтэй нэмэгдэж байсан улсын хөрөнгө оруулалтын өсөлт буурч, 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг өмнөх онуудаас бууруулж төлөвлөсөн.






# Хөрөнгийн зардал төсвийн зарлагыг бууруулах шаардлагын ихэнх хэсгийг өөртөө шингээжээ.

## 2015 оны төсвийн хөрөнгийн зардал

Их наяд төгрөг



Эх үүсвэр: Сангийн яам

# Улсын төсвийн нийт хөрөнгийн зардал дахь барилга байгууламжийн хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин буурсан.


## Тойм дүгнэлт

### Хөрөнгийн зардлын бүтэц (%)



- 2015 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт хөрөнгийн зардалд барилга байгууламж 47.9%, их засвар 2.3%, тоног төхөөрөмж 12.7% эзэлж байна. Нийт хөрөнгийн зардлын 35.07% буюу 519 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө гэсэн ангилалд оруулж тооцсон нь өмнөх жилүүдийн төсвийн хөрөнгийн зардлын бүтцээс ихээхэн ялгаатай байна. Бусад хөрөнгийн зардал хэсгийн дэлгэрэнгүй тайлбар төсвийн төсөлд тусгагдаагүй.
- Өнгөрсөн жил эхэлсэн боловч 2015 оны төсөвт суугаагүй 420 гаруй тэрбум төгрөгийн объект байгаа бөгөөд барилга, байгууламж дахь хөрөнгө оруулалтыг бууруулснаар он дамжин баригддаг дэд бүтцийн ажлуудыг зогсонги байдалд хүргэх эрсдлийг дагуулж болзошгүй юм.
- Хөрөнгийн зардлын дийлэнх хувь буюу 32.4%-ийг сангийн сайд, 24.9%-ийг зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд, 8.9%-ийг Уул уурхай, эрчим хүчний сайд, 6.3%-ийг БСШУ-ны сайд, 5.4%-ийг эрүүл мэндийн сайдад тус тус хуваарилсан.
- Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд, төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын бодлого, төсвийн чадавхид суурилсан төлөвлөх шаардлагатай.


# 2015 оны төсвийн гол ерөнхийлөн захирагч нарын хөрөнгийн зардлын зарцуулалт (эзлэх хувийн жин)



# Орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлж, аймаг нийслэл дэхь хөрөнгө оруулалтын шилжүүлэг нийт хөрөнгийн зардлын 13%-тай тэнцэнэ.

## Хөрөнгө оруулалтын шилжүүлэг

Тэрбум төгрөг



## Тойм дүгнэлт

- 2015 онд төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн шийдвэр гаргах эрх, бие даасан байдал болон хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг орон нутагт нь хөрөнгийн шилжүүлэг хэлбэрээр олгохоор тооцсон.
- 2015 онд аймаг, нийслэлд олгох хөрөнгө оруулалтын нийт шилжүүлгийн дүн 190.9 тэрбум төгрөг, үүнээс 24% буюу 45.9 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотод олгоно.
- Эдийн засгийн хямралт нөхцөл байдалд Засгийн газар орон нутагт эрх шилжүүлэх замаар төсөв батлах эрхийг хавтгайруулан олгох нь төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж болзошгүй.
- Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа нийгмийн чанартай олон барилга, байгууламжийн төсөв, санхүүжилтийг бүрэн шийдвэрлэлгүйгээр орон нутгийн мэдэлд шилжүүлж байгаа нь улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг алдагдуулах магадлалтай.

- 1 2014 ОНЫ ЭХНИЙ 3-Р УЛИРЛЫН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
- 2 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАНИЛЦУУЛГА
- 3 **ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ МЭДЭЭ**
- 4 ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

# Төсвийн гадуурх ихээхэн хэмжээний санхүүжилт улсын хөрөнгө оруулалтын төсөлд олгогдсон.

## МУХБ-ны зарцуулалт томоохон төслүүдээр

Тэрбум төгрөг

	2012	2013	2014
Авто замын төсөл	202	432	205
Суурь дэд бүтэц, гудамж төсөл	0	144	160
Эрдэнэс таван толгой	139	139	0
ХАА, Хөнгөн үйлдвэрийн 6 төсөл	0	271	0
Шинэ төмөр зам	0	272	38
Бусад	147	409	820
<b>Нийт</b>	<b>488</b>	<b>1667</b>	<b>1223*</b>

\* Хүлээгдэж буй гүйцэтгэл

Эх үүсвэр: Хөгжлийн банк, Монгол банк

МУХБ 2012 онд 488.4 тэрбум төгрөг, 2013 онд 1667.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн бөгөөд 2014 оны байдлаар нийт 1223 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр хүлээгдэж байна. МУХБ-ны санхүүжилтийн асуудлыг дараагийн хэлэлцүүлэгт дэлгэрэнгүй байдлаар авч үзнэ.

- 1 2014 ОНЫ ЭХНИЙ 3-Р УЛИРЛЫН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
- 2 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАНИЛЦУУЛГА
- 3 ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ МЭДЭЭ
- 4 **ДҮГНЭЛТ**

# Дүгнэлт

- ❑ 2014 оны 3-р улирлын байдлаар нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 42.2% буюу хангалтгүй түвшинд байна.
- ❑ 2014 оны 3-р улирлын байдлаар дэд бүтэц, нийгэм, үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар дахь улсын хөрөнгийн зардлын гүйцэтгэл 50%-иас доогуур байна.
- ❑ 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг өмнөх жилүүдээс бууруулсан.
- ❑ Улсын төсвийн нийт хөрөнгийн зардал дахь барилга, байгууламжийн хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин буурсан.
- ❑ Орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлж, аймаг нийслэл дэхь хөрөнгө оруулалтын шилжүүлэг нийт хөрөнгийн зардлын 13%-тай тэнцэнэ.
- ❑ Төсвийн гадуурх ихээхэн хэмжээний санхүүжилт улсын хөрөнгө оруулалтын төсөлд олгогдсон.



# Анхаарал тавьсанд баярлалаа!



Нээлттэй Нийгэм Форум  
Бодлогын хэлэлцүүлэг

Холбоо барих:

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамъян гүний гудамж 5/1

Улаанбаатар 14240 Монгол Улс

Утас: 976-11313207

Факс: 976-11324857

email: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)